



ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-Н ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

№ 001/002/H02/20260305 - 001

2026 оны 03 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл 59.4, 60 дугаар зүйл 60.1, 60.2, 76 дугаар зүйл, 76.1.2, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн №004/007/20240131-004 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 болон 4 дүгээр зүйлийн 4.2.2 дахь заалтад тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны (Бямба гараг) өдрийн 11.00 цагт **Монгол Улс, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Галлирей Улаанбаатар төвийн 3 давхарт Скай танхимд** болон Gazarshim.mn цахим хуудас, Gazarshim Uildver facebook page хуудсаар дамжуулан цахимаар болон танхимаар хуралдуулсугай.
2. **Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг** нэгдүгээр хавсралтаар, **саналын хуудасны загварыг** хоёрдугаар хавсралтаар, **хурлын нийтэд хүргэх зарын загварыг** гуравдугаар хавсралтаар, **хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг** дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 03 дүгээр сарын 27-ны (Баасан гараг) өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржэд 2026 оны 03 дугаар сарын 9-ны (Даваа гараг) өдрийн дотор шаардлагатай баримт бичгийн хамт тус тус хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын аль нэг сонин, “Газар шим үйлдвэр” ХК-ийн цахим хуудас болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 03 дугаар сарын 10-ны (Мягмар гараг) өдрийн дотор нийтэд мэдээлсүгэй. Хурал хуралдуулах тухай давтан зарыг 2026 оны 03 дугаар сарын 25-ны (Лхагва гараг) өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтэд мэдээлсүгэй.
6. Хурлын дэг, гарах шийдвэрийн төслүүд, санхүү, үйл ажиллагааны тайлан, тайлангийн талаарх дүгнэлт, ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн 2026

оны төсвийн санал болон холбогдох бусад баримт бичгийг бэлэн болгож, 2026 оны 03 дүгээр сарын 16-ны (Даваа гараг) өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.

7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлийн хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 11.00 цагаар тасалбар болгосугай.
8. Хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ц.Ганбатыг томилсугай.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

а. Хурал зохион байгуулах комиссын дарга: “Газар шим үйлдвэр” ХК-ийн
Гүйцэтгэх захирал Ц.Ганбат

б. Хурал зохион байгуулах комиссын гишүүд: р

“Газар шим үйлдвэр” ХК-ийн

Үйл ажиллагааы хариуцсан захирал З.Байгалмаа

Захиргаа, хүний нөөцийн албаны дарга Э.Ундрах

Санхүү төлөвлөлт, бүртгэлийн албаны дарга М.Хурцбилэг

Маркетингийн албаны дарга А.Цогтбаяр

Хуульч Л.Хаш-Эрдэнэ

Дотоод сүлжээний инженер Н.Энхтүвшин

10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

а. Тооллогын комиссын дарга: Би Ди Сек ҮЦК-ийн мэргэжилтэн Б.Онон

б. Тооллогын комиссын гишүүд:

Би Ди Сек ҮЦК-ийн мэргэжилтэн М.Оюунсүвд

Би Ди Сек ҮЦК-ийн мэргэжилтэн М.Мишээл

11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

12. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлэхийг Хурлын дарга (Гүйцэтгэх захирал Ц.Ганбат)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ш.АЛТАНБАГАНА